

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-11
<hr/>	
1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ./	3-5
2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./	5-11

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
08 дугаар сарын 20-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 27 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Галбадрах;

Чөлөөтэй: Д.Бум-Очир, С.Эрдэнэбат.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэржаргал, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Авид, мөн академийн Тэргүүлэгчдийн газрын дарга Б.Баярбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Монгол Улсын ерөнхий аудитор Д.Загджав, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, ахлах шинжээч Э.Цолмон, мөн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мэргэжилтэн Г.Мөнхзул, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Бямбасүрэн, Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ч.Энхтуяа, Аялал жуулчлалын бодлогын хэрэгжлтийг зохицуулах газрын ахлах шинжээч Н.Болормаа, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Авид, мөн академийн Тэргүүлэгчдийн газрын дарга Б.Баярбаатар, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Д.Рэгдэл нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 32 минут минут үргэлжилж, 15 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим,
15 цаг 27 минут

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ч.Ундрэм: Байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. 10 дугаар тойрог Отгоншарын Батнайрамдал ирээгүй байна. /Жагсаалт/ Дуламын Бум-Очир чөлөөтэй, 6 дугаар тойрог Шинэбаярын Бямбасүрэн ирсэн байн. /Жагсаалт/ Жанчивын Галбадрах чөлөөтэй. /Жагсаалт/ Амгаланбаатарын Ганбаатар ирсэн байна. 5 дугаар тойрог Гонгорын Дамдинням ирсэн байна. /Жагсаалт/ Бадрахын Найдалаа ирсэн байна. /Жагсаалт/ Цэндсүрэнгийн Мөнхтуяа ирсэн байна. /Жагсаалт/ Дүгэрийн Рэгдэл ирээгүй байна. /Жагсаалт/ Отгоны Саранчулуун ирсэн байна. /Жагсаалт/ Мягмардашийн Сарнай ирсэн байна. 5 дугаар тойрог Чинбатын Ундрэм ирсэн байна. 1 дүгээр тойрог Ганбатын Хосбаяр ирээгүй байна. /Жагсаалт/ Бадарчийн Хэрлэн ирээгүй байна. /Жагсаалт/ Сүхбаатарын Эрдэнэбат чөлөөтэй.

Байнгын хорооны гишүүн гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж 53,3 хувьтай ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

2 дугаарт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /2 дахь хэлэлцүүлэг/ явна. Ийм асуудал байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал дээр саналтай хүн байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Байнгын хорооны эхний хурал учраас та бүхэндээ дэг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.9 дэх хэсэгт Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хуралдаанаараа хэлэлцэх бөгөөд ийнхүү хэлэлцэхдээ хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг нягталж холбогдох Байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлнэ гэж заасан байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтныг танилцуулъя. Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээвэр хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд байна уу. Орж ирж байгаа юм байна. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч Н.Мандуул, Засгийн газрын Хэрэг эрхлэх

газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргын зөвлөх Батхуяг, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлах хянан шалгагч Анар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Хосбаяр, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Гэлэгжунай, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Төгөлдөр, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Очиртогтох, Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Энхжин, Сангийн Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Батмөнх, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн шинжээч Алтантуяа, Сангийн яамны төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Дашням, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн Цолмон, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Очиртогтох, Монгол Улсын

Үндэсний аудитын газар. Монгол улсын ерөнхий аудитор Загджав, Монгол Улсын ерөнхий аудиторовын орлогч Самбууням байна уу. Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын Аудитын удирдлагын менежер Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхтуяа.

Боловсролын яам. Боловсролын сайд Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир.

Эдийн засаг, хөгжлийн яам. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү байна уу. Дуудаарай. Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт хэрэгжилтийн газрын дарга Баттогтох, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Авид, Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газрын дарга Баярбаатар.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын дарга Даваажаргал. Тэнд байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Даваацэрэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батдорж. Тэнд орж ирж байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Бямбасүрэн. Дуудаарай. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Энхтуяа, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Баттулга. Баттулга даргыг дуудаарай. Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Гэрэл, биеийн тамирынхан. Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах ахлах шинжээч Болормаа. Ийм

бүрэлдэхүүнтэй албан тушаалтнууд хүрэлцэн ирсэн байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Гишүүд төслийн талаар бичгээр санал гаргаж болно. Санал гаргасан гишүүн саналаа тайлбарлаж үг хэлж болно.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу. Шилэнгээр тараагдсан том ном байгаа шүү дээ. 1 дүгээр зүйл дээр асуулт асууж, хариулт авах хүн байхгүй байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун танилцуулна.

15.37 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн /2 дахь хэлэлцүүлэг/-ийг хэлэлцэж эхэлнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дахиж танилцуулна. Ажлын хэсэг бол хэвээрээ байх юм байна. Саяын танилцуулсан хүмүүс.

Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Хурдтай хөгжлийн төлөөх зориг хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэсэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа.

Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх, эдийн засгийн өсөлтийг 5-6 ба түүнээс дээш хувьд инфляцыг 1 оронтой тоонд зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх хурдтай, зоригтой, эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх, хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

1 дүгээрт бүтэц бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн Их, бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, өөдөө тэмүүлэх Монгол буюу Гөү-Монголиа ган татлагат гүүр, Хөшигтийн хөндийн туннел, Хөшигийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн 5 цагариг авто замын төсөл, Шинэ Хархорин төсөл, Шинэ Зуунмод хот, Туул хурдны зам зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

2 дугаарт гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй бүсчилсэн хөгжил шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тодотголд тусгалаа.

3 дугаарт 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн

өрсөлдөөнийг нэмэгдүүлж либералчлах хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх, шилжилтийн үеийн зардлыг мөн тусгалаа.

4 дүгээрт Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль тогтоолын төслүүд батлагдсан. Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийлээ.

5 дугаар Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн ирээдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон билээ. Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ч.Ундрам: Жавхлан сайдад баярлалаа. Байнгын хорооны ирц дээр Дүгэрийн Рэгдэл /жагсаалт/ сая орж ирлээ. 1 дүгээр тойрог Ганбатын Хосбаяр сая орж ирлээ. /Жагсаалт/ Бадарчийн Хэрлэн сая орж ирлээ. Байнгын хорооны ирц 66,7 хувьтай болсон байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголын төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Д.Загджав танилцуулна.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн 3 намаас тууштай хөгжлийн төлөөх зориг гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34 дүгээр 34.1.4-д заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэж байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт 94,2

тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байгаа.

Танилцуулж дууслаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ч.Ундрам: Загджав Ерөнхий аудитор баярлалаа. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүн байна уу. Байвал нэрээ өгөөрэй. Кнопоо дараарай. Рэгдэл гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн асуулт асууя.

Г.Дамдинням: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Энэ төсвийн тодотголыг харахад Боловсролын сайдын төсвөөс үндсэндээ тэгээд шинжлэх ухааны салбарын төсвүүд нь хасагдаад явчхаж байгаа тийм л өөрчлөлт байгаа юм байна шүү дээ. Өөр ямар ч өөрчлөлт ер нь алга. Өөр 2, 3 тэрбум төгрөгийн өөрчлөлтүүд Боловсролын үнэлгээний төв гэсэн юмнууд дээр сайдын багц дээр нэг жсоохон жсоохон өөрчлөлтүүд харагдаж байх шиг байна.

Тэгэхээр би энэ Боловсролын сайд удахгүй бас Сангийн яамтайгаа төсөв оруулж ирнэ биз. Энэ дээр ер нь юу бодоод байгаа юм. Төсөв дээр 3 асуулт байгаа байгаа юм. 3, 4 асуулт.

1 дүгээрт би Боловсролын сайд томилогдсон цагаас хойш бас энэ хэвлэлээр мэдээлэл хийж байгааг хараад байгаа. Монгол Улсын Их Хурлаас 2023

оны 7 сарын 7-нд Боловсролын багц хуулийг баталж гаргасан. Боловсролын багц хууль ер нь бол бид нар ардчилсан тогтолцоонд шилжсэн цагаас хойш цоо шинээр боловсролоо нэг өөрчилчихье гэсэн цогц өөрчлөлтийг хийсэн. Энэ өөрчлөлтийн нэг том нэрийн хуудас нь бол англи хэлний боловсрол байгаа. Англи хэлний боловсролыг улс орон даяар ард нийтээрээ дэмжиж байгаад энэ хуульд 8 удаа хийх гэж оролдоод, 9 дэх дээрээ нэг ийм амжилттай болсон юм байгаа юм. 33 жилийн түүхэнд манай ардчиллын. Сүүлийн үед Боловсролын сайд маань харин энийг нэг зоонон өөлөх маягтай дуугараад байгаа харагдаад байгаа. Эхлээд 50 сургууль дээр турших юм ярьж байсан. Сүүлдээ 100 болж байх шиг байна лээ. Бүх нийтээр хэрэглэх ёстой шүү дээ. Хэрэгжих ёстой шүү дээ. Бүх нийтээр хэрэгжүүлэх бүх боловсролын тогтолцоонд англи хэлийг сургах энэ чиглэлд хөрөнгө оруулалтаа ирэх төсвүүд дээрээ тусгаж явна биз дээ гэж өөрөөс чинь асуумаар байна. 1 дүгээрт.

Энэ багшлах боловсон хүчнийг нь бэлдэх, тоног төхөөрөмжөөр хангах гээд 1 дүгээр асуулт. Энэ дээр ер нь ямар бодолтой байгаад байгаа юм.

2 дугаарт сая өнгөрсөн Засгийн газрын үед бас нэг юу болсон юм. Энэ боловсролын ерөнхий хуулийн хүрээнд энэ багшлах боловсон хүчин ажиллах албан хаагчдынхаа энэ нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд хөдөө, орон нутагт 3 жил ажилласан багшийг 5 жил ажиллаад тэгээд дараа нь 3 жил ажиллаад, ингээд 6 сарын цалинтай нэмэгдэх тийм урамшууллын тогтолцоог хийсэн юм. Орон нутагт ажиллаж байгаа бүсгүйчүүд маань хөөрхий бас нэлээн гомдол гараад декриттэй байх хугацааг нь тооцохгүй байна гэдэг ийм том гомдол гарсан юм. Тэгээд Засгийн газар бол эхний 1 жилийг нь тооцъё гэдэг шийдвэр гарсан. Тэгээд үүний эх үүсвэр суугаагүй юм уу. Суусан уу. Эсвэл тэр үедээ зохицуулаад болчихсон юм уу.

3 дугаарт бид нар PISA-гийн олон улсын үнэлгээнд боловсролоо хамруулсан. Олон улсын хэмжигдэхүүнд оруулсан гэсэн үг. Дэлхийн хаана явж байгааг харсан гэсэн үг. Үүний үр дүнгээр хийх ажлын төлөвлөлт, төсөв ямар байна вэ. Ийм 3 асуулт байна.

Ч.Ундрам: 2 дугаар микрофоныг өгье. Боловсролын сайд Наранбаяр.

П.Наранбаяр: Баярлалаа Дамдинням гишүүн ээ. Тэгэхээр би бол энэ англи хэлний боловсролыг харин ч сайн дэмжиж яваа сайдын нэг. Ямар нэгэн өөлсөн зүйл байхгүй. Та тэр өөлсөн юм байвал надад баримттай хэлээрэй. Зүгээр тантай бол яг санал нийлж байгаа нь бол үнэхээр энэ англи хэлний боловсролыг бол бид энэ 3 дугаар анги руу оруулах ажлыг ажил хэрэг болгож байгаа. 100 сургуульд *persen english* хөтөлбөрөөр заана. 3200 орчим англи хэлний багш байна. Хүрэлцэхгүй байна. Тийм учраас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 2000 англи хэлний багшийг гадаадад бэлдэнэ гээд оруулж ирж байгаа юм. Энэ төсвөө бол 2025-2026 оны төсөвт суулгахаар, мөн үүнтэй холбоотой Англофоны орнуудтай ярилцаж, дэмжлэг авахаар ярьж байгаа. Ялангуяа Английн зүгээс бол 10 сая фунт цетрингийн хэмжээтэй чадавхжуулахад чиглэсэн ийм амлалт авчихсан байж байгаа. Та бүхэн маань Девид Камерон айлчлах үедээ Монголд бол амласан. Үүний 1,5 сая бол ямар ч байсан энэ жилдээ ингээд шийдэгдэнэ гэсэн ийм юу бидэнд ирчихсэн байгаа. Тэгэхээр энийг бол бид нар тууштай хэрэгжүүлнэ. Тууштай хэрэгжүүлнэ шүү.

Тэгээд энэ ажлыг бол бид ямар ч байсан энэ 2025-2026 ондоо энэ багш нараа бэлдэх дээр мөн 100 сургууль дээр хэрэгжүүлсний ирээдүйд 870 гаруй сургуулил дээр бүгд дээр нь хэрэгжүүлэх энэ ажлыг эхлүүлнэ. Явуулна гэдгээ танд хэлье.

Энэ 2 дугаар асуултын тухайд манай Батцэцэг хариулчих уу. PISA-гийн үр дүнгээр хийх ажлын тухайд бол манайхан дээр нь нэмж хэлээрэй. Ялангуяа унших чадвар их сул гарсан. Маши сул гарсан. Тэгэхээр унших чадварыг сайжруулах асуудлыг бид ярилцаж, энэ жилээс сурах бичиг үндэсний хөтөлбөрийг шинэчлэх ажил Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн дээр голлоод, манай судлаачид оролцоод хийгээд явж байгаа. Энэ унших бичиг гэдэг хуучин байсан энэ сурах бичгээ сэргээгээд ашиглаад явахаар ярьж байгаа. Энэ дээр бас иж бүрэн ийм судалгаа хийсний үндсэн дээр бид энэ ажлыг төгөлдөржүүлэх ийм юмыг хийнэ гэдгээ хэлье. Ингээд Батцэцэг 2 дугаар асуултад хариулна.

Ч.Ундрам: Нэмж хэн хариулах вэ. 1 дүгээр микрофон. Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя. Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг. Боловсролын багц хууль батлагдсантай холбогдуулан хөдөө орон нутагт 5, 3 жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа багш ажилтныг 5 жил тутамдаа 6 сартай тэнцэх хэмжээний тэтгэмж, цаашид 3 жил тутамд нь 6 сартай тэнцэх хэмжээний тэтгэмжийг бол олгож ирж байгаа. Нийтдээ 2024 оны төсөвт 14.512 хүнд 105,4 тэрбум төгрөгийн бол төсөв батлагдсан. Декреттэй байгаа албан хаагчийн хувьд бид бүхэн 1 жилийг нь бол тасралтгүй ажилласан жилээр тооцох Засгийн газрын тогтоолдоо журамд өөрчлөлт оруулаад ингээд тооцоод явж байгаа. Тэгэхээр тасралтгүй ажилласан 5, 3 жилд бол 1 жил хүртэл чөлөөтэй байгаа, декреттэй байгаа багш, албан хаагчид бол ороод явж байгаа гэсэн үг.

2025 оны төсөвт бол бас бүрэн хэмжээгээр суулгаад явж байгаа. 2024

оны төсөвтөө багтаад бид нар санхүүжилтээ олгоод явж байгаа

Ч.Ундрам: Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Яах вэ, бид нар бүгдээрээ л олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг харж байгаа байх. Тэгээд л 50 сургууль гээд л, 100 сургууль гээд л. Монгол хэлний боловсрол гээд л. Ер нь бол Монгол хэлний боловсрол муу байгаад англи хэл огт буруугүй. Англи хэлний боловсролыг хүмүүс сонгоод байгаад Монгол хэл бас буруугүй. Тэгэхээр аль алийг нь сайжруулах тухай асуудлыг зэрэг яриад явна уу гэхээс тэр нь ч ийм, энэ нь ч ийм уугуул Монгол хүн байхгүй болох гээд байна гээд нөгөө Монгол ялна стилийн тайлбаруудыг чинь харсан шүү. Та бид 2 тэр баримт сэлт яриад яах вэ. Хийх гээд байгаа бол сайн байна. Би яг танд бас хэлье гэж бодож байсан юм. Английн элчин сайдтай уулзсан. Английн элчин сайд тэр 10 сая паундыг бас бушуухан аваач гэдэг асуудлыг яриад байгаа юм. Англофон элчин сайдуудтайтай би бас өмнөх сайдтай цуг уулзаж байсан. Тэгэхээр энэ гадаадын төсөл хөтөлбөрүүд дээрээ анхаарал тавиад бид нар бол 2 жилийн хугацаанд энэ англи хэлний багш нарын дутагдлаа нөхчих юм байна лээ шүү дээ. Энэ ажлаа бол та бас жоохон эрчимжүүлээд хийчихвэл зүгээр байх.

Дараагийн 4 дэх асуулт бол энэ мэргэжлийн боловсролын салбарын тоног төхөөрөмжүүд дээрээ жоохон хөрөнгө оруулалтын асуудлуудыг та жоохон тавьж өгөхгүй байсан юм уу. Яагаад вэ гэвэл бид нарт мэргэжилтэй боловсон хүчин хэрэгтэй болчихоод байгаа юм. Бүх хүн дээд боловсролтой. Техникийн боловсролтой яг одоо өндөр цалинтай энэ ажлыг хийдэг хүмүүс маш багасчхаад байгаа юм. Энэ салбарт сурч энэ салбар Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам руу яваад 10 жил дамнуурч дамнуурч арай гэж боловсролын салбартаа ирсэн. Энэ

салбараа яамны хавсарга шиг битгий авч яваарай. Энэ салбарынхаа тэр дадлагажих тоног төхөөрөмж, тэр хэрэглэгддэг бараа, бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтууд дээр нь бас жоохон ахиухан юм тавьж өгөх тал дээр та нар бас юм бодоорой л гэж хэлье дээ.

Ч.Ундрэм: Санал гэж хүлээж авлаа. Дараагийн асуултыг Рэгдэл гишүүн асууна.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ 2024 оны улсын төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй цуг орж ирж байгаа энэ Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслөөс ганцхан асуулт байгаа юм. Энэ бол ерөнхийдөө бас ойлголт муутай хүн учраас асууж байгаа юм шүү нөхөд өө. Энэ Баялгийн сангийн тухай хууль батлагдсан явдал бол бас их том ололт болсон. Тэгээд энэ дотроо 3 сантай гээд ингээд бид нар ерөнхий ойлголттой яваад байгаа. Тэгээд энэ баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд бол 2 сан нь бол энэ сандаа хуримтлалтай, мөнгөтэй төгрөгтэй юм байна. Нөгөө биднийг их сонирхоод байдаг хөгжлийн сан маань байхгүй юм байна. Энэ хөгжлийн сангийн хөрөнгө цаашдаа энэ 2024 онд, ер нь цаашдаа яасхийж явах юм болоо гэсэн нэг ийм асуулт байна.

Ч.Ундрэм: Сангийн сайд Жавхлан хариулах уу. 6 номер. Сангийн яам.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Үндэсний баялгийн сангийн тухай хууль энэ оны 2024 оны 4 сарын 19-ний өдөр батлагдсан байгаа. Уг хуулиар бол дотроо 3 сантай. Үүнээс бол яг таны асууж байгаа хөгжлийн сангийн эх үүсвэр нь бол уг хуулийн 11.1.3-аар бол зохицуулагдаж байгаа. Энэ дээр юу гэж заасан бэ гэхээр хөгжлийн сангийн эх

үүсвэр нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ нь тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байснаас нэмэгдэж орох төсвийн орлогын 50-аас дээш хувиар бүрдэнэ гээд заачхаад байгаа юм. 2024 оны төсвийн тухай хууль анх батлагдахдаа болон бидний бас тодотголоор энэ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар бол тэнцвэржүүлсэн тэнцэл маань бол -2 хувьтайгаа байхаар бол бид оруулж ирсэн байгаа. Тэгэхээр энэ нөхцөл хангагдаагүй учраас хөгжлийн санд бол эх үүсвэр хуримтлагдахаар бид нар баялгийн сан дээр бол тусгаагүй байгаа гэсэн үг. Нөгөө 2 нь бол яг хуулийнх нь дагуу бас тусгагдаад явчхаж байгаа гэсэн үг.

Ч.Ундрэм: Рэгдэл гишүүн хариулт хангалттай юу.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ирцэд 10 дугаар тойрог Отгоншарын Батнайрамдал гишүүн ирсэн байна. Мөн одоо байнгын хорооноос гадуур Энхтүвшин гишүүн, Зулхар гишүүн, Аубакир гишүүд бас Байнгын хорооны хуралд сууж байгааг танилцуулъя. Байнгын хорооны албан ирц 80 хувьтай болсон байна гэдгийг хэлмээр байна.

Одоо санал хураалт явуулж эхэлнэ. Хуулийн төсөлтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Тэгвэл санал хураалт явуулчихъя. Төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинням Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна. Манай Байнгын хороо биш шүү дээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны

*төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь
хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.*

*Хэлэлцэх асуудал дууссан тул
өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан
өндөрлөснийг мэдэгдье.*

15.59 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ